



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/119

Бат-Өлзий сум

Цусан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх  
өргөн туршилтын дархлаажуулалтын ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын үхэр сүргийн 70 хувьд цусан халдварт өвчнөөс урьдчилсан сэргийлэх өргөн туршилтын дархлаажуулалтыг 2022 оны 09 дүгээр сарын 20-оос 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулахыг (“Хустын рашаан”, “Хутагт уулын өгөөж” Мал эмнэлгийн нэгжүүдэд) үүрэг болгосугай.
2. Цусан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх өргөн туршилтын дархлаажуулалтын хуваарийг хавсралтаар баталсугай.
3. Дархлаажуулалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (П.Аюушжав)-д даалгасугай.
4. Дархлаажуулалтанд шаардагдах 55,000,000 (тавин таван сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

Сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр  
сарын 20-ны өдрийн 4/1 дугаар  
захирамжийн хавсралт

ЦУСАН ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ӨРГӨН ТУРШИЛТЫН  
НАМРЫН ДАРХЛААЖУУЛАЛТЫН 2022 ОНЫ ХУВААРЬ

№	МЭҮН-н нэр	Багууд	Нийт үхэр сүргийн тоо	Хамрагдах үхрийн тоо
1	Хустын Рашаан	1-р баг	9041	6330
		2-р баг	9893	6930
		6-р баг	15430	10801
			<b>34364</b>	<b>24061</b>
2	Хутагт уулын өгөөж	3-р баг	5374	3762
		4-р баг	8617	6032
		5-р баг	3935	2755
			<b>17926</b>	<b>12549</b>
	<b>Бүгд:</b>		<b>52290</b>	<b>36610</b>

--oOo--